



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 17 өдөр

Дугаар A/23

Батноров сум


Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт явуулах журам”-ын 9.1, 9.2, 9.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Засаг даргын 2024 оны A/102 дугаар захирамжийн дагуу малчдын хоршоонд газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтын төслийг үнэлж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Э.Зулцэцэг (Газрын даамал)
Гишүүд:	Л.Амармэнд (Санхүүгийн албаны дарга)
	Ч.Чинхүсэл (ХАА-н тасгийн мэргэжилтэн)
	А.Эрдэнэтуяа (Хууль эрх зүйн мэргэжилтэн)
	Б.Чимэгсүрэн (Нийгмийн бодлогын түшмэл)

2. Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах явуулах журам”-ын дагуу зохион байгуулахыг Ажлын хэсэгт үүрэг болгосугай.



Б.ЖАВХЛАНБАЯР